

ГЭР БҮЛД НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АВАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

А. Долгор

Нийгмийн ажлын докторант

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

ayushdolgor@yahoo.com

Хураангуй: Манай орны хувьд эрх, гэр бүлийн асуудал төрийн анхааралд байдаг чухал асуудал юм. Гэсэн хэдий ч бодлогын заалт нийгмийн асуудал, гэр бүлд чиглэсэн үйлчилгээгээр төдийлөн хэрэгжиж чадахгүй, судалгаанд хамрагдсан 30 гэр бүлийн 42 хүүхэд төрөл бүрийн хүчирхийлэлд өртсөн нас, хүйс, нийгэм сэтгэл зүйн онцлог, сөрөг нөлөөллийн байдлаас харахад өөрийгөө үнэлэх үнэлэмжгүй, худал үнэний зааг ялгааг олохдоо харалган, уур бухимдлаа илэрхийлэхдээ зөрчилд орох, байнга гэмт хэрэгт өртөх эрсдэл өндөр, харилцааны болон архины хамааралтай гэр бүлд хүмүүжиж байгаагийн улмаас гэрээсээ дайжих явдал нилээн байна. Эцэг, эхийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, хүүхдийг сурч хөгжихөд дэмжлэг үзүүлэх гэр бүлийн орчинг сайжруулахад чиглэсэн сургууль, цэцэрлэг, гэр бүл, хүүхдийн байгууллагад түшиглэсэн эцэг, эхийн боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулах зайлиггүй шаардлага байна.

Түлхүүр үгс: Нийгмийн ажил, үйлчилгээ, гэр бүл, архины хамаарал

I. УДИРТГАЛ ХЭСЭГ

Гэр бүл төр улсын үндэс, төр улс дахь гэр бүл болдог нийгмийн анхдагч орчин. Гэр бүл нь сэтгэл зүй, ёс суртахуун, эдийн засаг, эрх зүй зэрэг нийгмийн олон төрлийн харилцааг өөртөө багтаасан өвөрмөц орчин байдаг. Олон улсын гэрээ, конвенцүүдэд гэр бүлийг нийгмийн анхдагч хэмээн заасан байдаг нь гэр бүлийн бүтэц, гэр бүлийн тухай ойлголт, хандлага, нийгмийн хөгжлийн зүй тогтлын дагуу өөрчлөгдөн хөгжиж, улам боловсронгуй болж байх жамтайг хүлээн зөвшөөрсний илрэл юм.

Гэр бүлийн гишүүдийн ашиг сонирхол, хүний эрх, эрх чөлөөний нэгэн адил хууль тогтоомж, төрийн бодлогоор хүлээн зөвшөөрөгдөж, хамгаалагдаж байж хүн бүрт тэгш хүртээлтэй, үнэ цэнэтэй, ач холбогдолтой болдог. Төрөөс энэ үүргээ хэрэгжүүлж, үндсэн хуулийнхаа 16 дугаар зүйлийн 16.11-д “гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан төдийгүй 1999 онд Монгол улсын гэр бүлийн тухай хуулийг батлан гаргасан билээ. Түүнээс хойш төр гэр бүл, хүүхдийн талаархи эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар бодлого, хөтөлбөр зэрэг хэд хэдэн бичиг баримтууд бичгүүд болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хууль зэргийг батлан, хэрэгжүүлэх арга хэмжээг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна.

Гэр бүл цуцлалт, гэр бүлийн таагүй уур амьсгал, хүчирхийллийн харилцаанаас үүдэн олон хүүхэд гэр бүлдээ аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл, үл хайхрах явдалд өртөж, аюулгүй эсэн мэнд амьдрах, хөгжих суурь эрх нь зөрчигдсөөр байна. Хуулийн болон хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарч цаашид гарах эрсдэлээс сэргийлэх шаардлага гарч байна. Гэр бүлийн ёс зүй, үнэ цэнэ, хөгжлийн хадгалснаар улс орны хөгжилд нөлөөлөх маш том гарц юм.

II. ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 -д "...Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална", Монгол Улсын Их Хурлын 2003 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого" –д гэр бүлийн амьдралын түвшинг тасралтгүй дээшлүүлж, гэр бүлийн харилцаа, ёс зүйн эрүүл орчин, түүний нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх таатай нөхцлийг бүрдүүлэх замаар монгол хүний хөгжлийг дэмжихэд энэхүү бодлогын эрхэм зорилго оршино хэмээн тус тус тодорхойлж хуульчилсан бол Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогод "Тэр бүл нь хүний амьдралын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж, түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын анхааралд байлгана" гэж заасан нь өнөөгийн төр, засгаас гэр бүлийн талаар баримтлах бодлогын үндэс болж байна. Монгол улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого, "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.4.2-т гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, бат бөх хариуцлагатай гэр бүлийг дэмжин, хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхээр тусгагдсан.

Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1-2.6-д Хүний хөгжлийн талаар дараах цогц үйл ажиллагааг хүн амын бүлэг тэр дундаа гэр бүлд чиглүүлэхээр тусгажээ Үүнд:

- Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

- Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжих

- Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх

- Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж,

дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлэх

-Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлэх

- Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болох чиглэлүүдээр тусгагдсан.

Хүний хөгжлийн анхдагч орчин болсон гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах тогтолцоог үндэсний хэмжээнд бэхжүүлэх, гэр бүлийн гишүүдийн эрхийг баталгаажуулах чиглэлээр эрх зүйн таатай орчинг бүрдүүлсэн сайн талтай ч хэрэгжилт тодорхойгүй л байна. Үндэсний статистикийн хороо, ЦЕГ-тай хамтран гэр бүлийн хүчирхийллийн хохирогч үйлдэгчийн судалгаа гаргажээ. 2020 оны эхний 3 сард гэр бүлийн хүчирхийллийн 3131 зөрчил шалгагдсанаас 2244 зөрчлийг шийдвэрлэсэн байна. Харин гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт шалгагдсан 10 эрэгтэй тутмын зургаа нь 25-39 насныхан байгаа бол 10 эмэгтэй тутмын зургаа нь 18-34 насныхан байна. Дээрээс харвал хүн бүрт хэрэгцээтэй нийгмийн ажлын үйлчилгээг хүргэх нь нэн тэргүүний асуудал болоод байгаа шаардагдаж байна.

Иргэдийн хуучин сэтгэлгээг шинэ дадал хэвшилтэй болгох, тэднийг зөв зам руу хөтлөн оруулах нь нийгмийн ажилтны чухал үүрэг юм. Гэвч бодит байдалд эсрэгээрээ буюу нийгмийн ажлын үйлчилгээг авагч иргэдийн тоо жил ирэх тутам маш ихээр өсч байгаа.

Түүнчлэн Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа Наркологийн эмнэлгээс СУРГУУЛИЙН насны хүүхдүүдийн дунд тодруулбал, ерөнхий боловсролын сургуулийн 12-17 насны 7000 хүүхдийн дунд явуулсан судалгаагаар 6.1 хувь нь архийг хэтрүүлэн хэрэглэх буюу “тасартлаа ууж үзсэн” гэж хариулжээ. Мөн 30 орчим хувь нь “11-14 насандаа архийг анх хэрэглэж үзсэн” гэсэн кейсүүдийг авч үзвэл гэр бүлийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэхэд нийгмийн ажлын үйлчилгээгээ сайжруулах зайлшгүй шаардлага тулгараад байна. Нийгмийн ажлын үйлчилгээ нь иргэдийн сэтгэл зүйн болон эрх зүйн мэдлэг, чадварыг дээшлүүлэх тэдний хувийн асуудлаа төлөвлөхөд нь туслах дэмжих ёстой байтал нийгмийн анхан шатны нэгж болох гэр бүлд нийгмийн ажлын үйлчилгээ авахад чиглэгдэх шинэ нөхцөл байдал хэдийн үүсжээ.

Гэр бүл нь анхдагч нэгж болох, хүүхдийн хүмүүжлийг олгох чухал хэсэг болохынхоо хувьд эцэг эхийн гэр бүлдээ цаг зав гаргах нь багассан, амьд харилцаа цөөрсөн энэ цаг үед гэр бүлийн хөгжлийн бодлоготой хамааралтай асуудал нийгмийн ажлын салбарын нэг чухал асуудал юм. Өрх гэр бүлийн нэг нэгнээ гэсэн сэтгэл, эцэг эх үр хүүхдээ гэсэн сэтгэл, үр хүүхэд нь эцэг,эхээ асран

хамгаалах, хайрлах хандлага нь гэр бүлийн оршин тогтнох, гэр бүлийн үнэ цэнийг хадгалж байдаг. Өрх гэр бүл сайн сайхан байвал нийгэм тэр чинээгээрээ эрүүл, саруул байх болно. Нийгмийн ажлын үйлчилгээ хүртэх нэг том бааз бол гэр бүл юм.

Ш. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Төрийн бодлого нь гэр бүлийн сайн сайханд чиглэн, туслан дэмжих үүрэгтэй. Салбаруудын уялдаа холбоог сайжруулснаар хөрөнгө мөнгө хэмнэх, зорилтот бүлэгт үйлчилгээг оновчтой хүргэх, үйлчилгээний чанар хүртээжийг сайжруулах бүрэн боломж нөөц бий. Өнөөдөр архиы хамааралтай гэр бүлд амьдарч байгаа хүүхдүүдийн асуудал нэн тэргүүний асуудал болоод байна. Сүүлийн жилүүдэд хийсэн судалгаагаар гэрлэлтээ цуцлуулагчид салалтын байдалтай гэр бүл буюу амьдралдаа итгэл алдарсан (34%), санхүүгийн бэрхшээл (47,3%), гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг (41,3%) гэр бүл байна гэсэн бүрэн бус тоо байна. Гэр бүлээ цуцлуулсан өрхийн 70.0 хувь нь 0-15 насны дунджаар 2 хүүхэдтэй байна. Өрхийн хүн амын дундаж тоо буурч, 2016 онд хотын нэг өрх дунджаар 4.7, хөдөөгийн өрх 4.3 гишүүнтэй болсон байна. Хотын 3 өрх, хөдөөгийн 5 өрх тутмын нэг нь нийлмэл өрх буюу ах дүү, садан төрлийн хамт амьдарч буй өрх байна.

Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, гэр бүлийн хөгжил, боловсрол, тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй гэр бүлийн орчныг дэмжих, гэр бүлийн гишүүдийн тэгш оролцоог хангах нөхцлийг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага үгүйлэгдэж байна.

Үндэсний Статистикийн Хорооноос 2017 онд улсын хэмжээний “Жендэрт суурилсан хүчирхийллийн түүвэр судалгаа”-г анх удаа зохион байгуулсан. Судалгааны дүнгээр МУ-д гурван эмэгтэй тутмын нэг (31.2%) нь амьдралынхаа туршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Гэр бүлийн хүрээнд тухайлбал, нөхөр/хамтрагчийн зүгээс 10 эмэгтэйн 6 нь (57.9%) амьдралынхаа туршид хүчирхийлэлд өртсөн. Эдгээр эмэгтэйчүүдийн 4 хүн тутмын 1 нь (26.5%) хэн нэгэнд хандаж, хэлж байгаагүй байна.

Иймээс нийгмийн ажлын үйлчилгээний талаар шаардлагатай судалгаа, эрдэм шинжилгээний ажлын чиглэлийг тогтоон, гэр бүлийн харилцаанд гарч буй өөрчлөлт хандлагыг тодорхой хугацааны давтамжтайгаар судалж үр дүнг бодлого хөтөлбөрт тусгаж ажиллах, нийгмийн ажлын чиглэлээр мэргэшсэн судлаачдыг дэмжих, бусад орны мэргэжлийн байгууллага, хүмүүстэй харилцан туршлага солилцож, судалгаа шинжилгээний хүрээгээ өргөжүүлэх, хамтрах, судалгаа, ном сурах бичгийг олон нийтийн хүртээл болгоход санхүүгийн дэмжлэг үзүүлэх,

нийгмийн ажлын үйлчилгээний талаар судалгаа, бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хяналт үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх асуудлаар төрийн ба төрийн бус байгууллагын чадавхийг бэхжүүлэх, олон улсын болон хөгжлийн байгууллага, агентлагийн гэр бүл, хүүхдийн хөгжилд зориулж байгаа дэмжлэг, туслалцаа, хөтөлбөрүүдийг төрийн бодлоготой уялдуулах, гэр бүл, хүүхдийн эрх ашигтай холбоотой үндэсний бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах бүх шатны арга хэмжээг өргөжүүлэх, эцэг, эхийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, хүүхдийг сурч хөгжихөд дэмжлэг үзүүлэх гэр бүлийн орчинг сайжруулахад чиглэсэн сургууль, цэцэрлэг, гэр бүл, хүүхдийн байгууллагад түшиглэсэн эцэг, эхийн боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулах зайлшгүй шаардлага байна.

Нийгмийн ажлын үйл ажиллагааны хамтын ажиллагааг сайжруулснаар иргэдэд хүрэх үйлчилгээ цогцоор хүргэж чадах бөгөөд илүү үр дүнтэй, үйлчлүүлэгчдэд дахин эрсдэлтэй нөхцөлд орохоос урьдчилан сэргийлж байгаа юм. Асуудал үүссэн хойно нь биш эрсдэлээс урьдчилан сэргийлэх гол ажил юм. Архины хамаарлаас болоод сэтгэл санаа, эд хөрөнгийн хохиролд орсон байдаг ба гэр бүлд байгаа хүүхэд, эмэгтэйчүүд өндөр эрсдэлтэй байдаг. Үйлчилгээ үзүүлдэг салбарууд салангид ажиллах биш хамтран, үр дүнг хамтран тооцож ажиллах нь нийгмийн эрүүл байдлыг хангахад чиглэгдэж байгаа.

IV. ДҮГНЭЛТ

Гэр бүл бол нийгмийн чухал хэсэг. Гэр бүлийн орчин хүүхдийн хүмүүжилд чухал нөлөө үзүүлэх болсон энэ цаг үед ар гэрээ тэжээхийн тулд амрах завгүй зүтгэж үр хүүхдэдээ зориулах цаг улам бүр багасч буй гэр бүлүүд нь ихэвчлэн ядуу, дундаж амьдралтай иргэд байна. Хүүхэд бүр хэн нэгнийг дууриаж түүнээс үлгэр авч өсөж хүн болдог. Судалгааны ажлын хүрээнд хүүхдүүд хүчирхийлэлд өртөх, нийгэм сэтгэл зүйн сөрөг нөлөөллийн байдлаас хамаарч өөрийгөө үнэлэх ццашлаад үнэлэмжгүй болох, худал үнэний зааг ялгааг олж чадахгүйгээс бусдад уруу татагдах, уур бухимдлаа илэрхийлэхдээ зөрчилд орох, гэмт хэрэгт өртөх, гэр бүлийн хараа хяналт сул, үл хайхрах байдлаас үүдэн гэрээсээ дайжих явдал ч түгээмэл байна. Харин үүний хохирогч болсон хүүхдүүд хаана хандах, хэнд хэлэхээ мэдэхгүй өөрөөр хэлбэл сэтгэл зүйн хамгаалалт байхгүйгээс айдас, ганцаардалд насан туршийн буруу хүмүүжил олох болсноор нийгэм дэх ёс зүйгүй нөхцөл байдал нэмэгдэж байна. Гэр бүлд хамгийн том асуудал олсон архины хамааралыг Оросын сэтгэл зүйч Вайка Разинкова “үл үзэгдэх эмгэнэл” гэж тодорхойлсон байдаг. Гэр бүл гэдэг бие биеэнтэйгээ харилцаатай сэтгэл хөдлөлийн хүчтэй дасал болсон холбоонд оршиж байх учиртай. Гэтэл эцэг эхчүүд гэр бүлийн гишүүдээ нэгтгэх гэсэн өөрийн дүрэм, хэрэгтэй үед сэтгэл санааг нь дэмжих чадваргүйгээс улс орны хөгжлийн суурь болсон “гэр бүлийн дархлаа”

суларч байгаа нь нийгмийн ажил үйлчилгээнд дараах асуудалд өөрчлөлт шинэчлэл хийх нь зүйтэй хэмээн үзлээ.

1. Нийгмийн ажлын үйлчилгээг халамж хэмээн ойлгодог байдлыг өөрчлөх
2. Материаллаг тусламжтай энэ зэрэгцэхүй сэтгэл зүйн тусламж үзүүлэх
3. Дунд сургуулийн ахлах ангид гэр бүлийн тухай олгох мэдлэг, сургалт явуулах нийгмийн ажилтныг бэлтгэх
4. Нийгмийн ажилтныг мэргэжүүлэх. Тухайлбал, хүүхэдтай, ахмадуудтай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй, өрх толгойлсон эцэг, эхтэй ажиллах зэрэг
5. Нийгмийн ажлыг үйлчилгээг цогц байдлаар хүргэх мэргэшсэн багийн ажиллуулах
6. Нийгмийн ажилтан мэргэжлээр төгсөгчдийг мэргэжлээр ажиллах боломжийг өргөжүүлэх
7. Энэ салбар ажиллаж буй мэргэжлийн бус ажилтнуудын давтан сургалт, мэргэшүүлэх сургалтанд хамруулах
8. Нийгмийн ажлын үйлчилгээг төрийн бодлогын “чухал” хэсэг болгох
9. Хүүхдийн байгууллагад түшиглэсэн эцэг, эхийн боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэргийг дурьдаж болно.

НОМ ЗҮЙ

1. Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. Суурь судалгаа. УБ.2010
2. Батцэнгэл.Т, Бандхүү.Б Гэр бүлийн сэтгэл судлал УБ. 2016 он
3. Дунгаамаа А. Гэр бүлийн эрх зүй УБ. 2016 он
4. Намжил Т. Монгол гэр бүлийн ёс, уламжлал УБ. 2005.
5. Намжил Т. Гэр бүл: Орчин үеийн асуудлууд. УБ. 2005. XI дэвтэр.
6. Монгол улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого 2003
7. Ольга Шувалова Энергетика семьи. Санкт-Петербург Изд-во “Невский проспект” 2002.
8. Пэрлээ Х. Нэгэн гэрийн түүхийн тухай. УБ. 1958.
10. Шон Берн Гендерная психология. /секреты мужчины и женщины/ СанктПетербург Изд-во “прайм-ЕВРОЗНАК” 2001.
11. WINFIELD, F. E. (1985) *Commuter Marriage: Living Together, Apart*. New York:
12. *Columbia University Press*.